

**БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР**



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тэшиг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн ХУРААНГУЙ тайлан

Аудитын код: БУА-2024/4/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас: 70342580 Цахим хаяг: Erdeneb@audit.gov.mn Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn Аудитор: Б.Энхтөр Утас: 70342495 Цахим хаяг: enkhturb@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.03.25 № 323

танай _____ ны № _____ т

БУЛГАН АЙМГИЙН ТЭШИГ
СУМЫН ЗАСАГ ДАРГА
Ж.ГАНСҮХ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Тэшиг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тэшиг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төсвийн төслийн саналыг 1,513.6 сая төгрөгөөр өгсөн боловч тус саналаас зардлыг 764.3 сая төгрөгөөр нэмж 2,277.9 сая төгрөгөөр баталсан байна.

Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй төлөвлөсөн боловч орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт өссөн, засгийн газрын тогтоолоор цалин нэмэгдсэн, оны эхний үлдэгдлийг нэмж баталсан шалтгаалаан нэмэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн

006020742

дүгнэлт гаргаагүй болно.

Үндсэн хөрөнгийн хэмжээ өмнөх оноос 1,098.2 сая төгрөгөөр өсөж, нийт хөрөнгө 1,383.5 сая төгрөгөөр өссөн нь "Тэшиг-Ус" ОНӨААТҮГ нь халаалтын тогоо, авто машин, 76 метр инженерийн шугам хоолой, ЗДТГ-т үйлчилгээний зориулалттай 6 газар зэргийг орлогод авсантай тус тус холбоотой байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 2023 онд 148 арга хэмжээ төлөвлөж үүнээс 143 арга хэмжээ бүрэн биелэж 96.6 хувьтай дүгнэгджээ.

АДБОУС 2706. 10-д зааснаар хууль тогтоомжоор хориглоогүй, аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй, тухайлбал аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүссэн тухай, санхүүгийн тайлангийн аудит, аудитын тайлантай холбоотой аудиторын хүлээх үүрэг хариуцлагын тухай дэлгэрэнгүй тайлбар өгөхөөр хууль тогтоомжоор шаардсан мэдээллийг тусгана.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	898,013,265.11	1,183,340,323.29
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	955,515,144.89	2,053,726,236.59
Нийт хөрөнгийн дүн	1,853,528,410.00	3,237,066,559.88
Нийт өр төлбөрийн дүн	758,910,795.76	822,806,497.92
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,094,617,614.24	2,414,260,061.96
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,853,528,410.00	3,237,066,559.88
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	3,657,895,953.58	5,112,458,542.38
Үйл ажиллагааны зардлын дүн	3,497,177,152.87	3,883,203,917.22
Үйл ажиллагааны үр дүн	160,718,800.71	1,229,254,625.16
Үйл ажиллагааны бус үр дүн	4,322,486,129.08	28,843.12
Үйл ажиллагааны нийт үр дүн	-4,161,767,328.37	1,229,225,782.04
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл		5,256,384,942.61
Тайлант оны үр дүн		1,229,225,782.04
Эцсийн үлдэгдэл		2,414,260,061.96
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	3,583,478,461.17	4,652,646,032.55
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	2,865,985,688.09	3,873,453,670.68
Үйл ажиллагааны ЦМГ	717,492,773.08	779,192,361.87
Хөрөнгө оруулалтын ЦМГ	-455,334,486.00	-493,546,572.00
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-99,718,923.00	-65,553,999.00
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	162,439,364.08	220,091,790.87
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	407,867,898.28	570,307,262.36
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	570,307,262.36	790,399,053.23
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2,643,840,200.00	1,987,593,006.35
Урсгал зардал	1,645,405,200.00	1,466,594,335.35
Хөрөнгийн зардал	869,935,000.00	452,944,672.00
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		
Улсын төсвөөс санхүүжих		
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	599,922,900.00	95,068,710.00

Гурав. Аудитын илрүүлэлт

Илрүүлэлт-1:

Аудитаар нийт 8,032.2 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 2,604.7 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 5,427.5 мянган төгрөгийн 2 зөвлөмж, 1 албан шаардлага өгсөн.

- Бараа материалын тодруулгын аж ахуйн материалын дансанд 0.014 сая төгрөгийг зөрүүтэй тусгасан.
- Үндсэн хөрөнгийн барилга байгууламж, орон сууц, машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшлын дансны бичилтийг орлого талд 24.9 сая, зарлага талд 25.4 сая төгрөгийг зөрүүтэй тусгасан.

- Тэшиг сумын ЗДТГ-т 671.4 сая төгрөгийн үнэлгээтэй 6 газрыг орлогоор бүртгэж баланст тусгууллаа.

5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт-1

Ан амьтан барих зөвшөөрлийг тул загас 29, зэрлэг гахай 6, бор гөрөөс 11, загас 200 ширхэг зөвшөөрлийг бичиж 32,676.0 мянган төгрөгийн орлого төвлөрөх боловч 2,604.7 мянган төгрөгийн орлогыг авлагаар тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д *"дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"* Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх *"Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ"* 41.2.1 дэх *"хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх"* гэсэн заалттай тус тус нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Нийт 154 мэдээлэл оруулахаас 3 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д *"Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх"* гэж заасныг хэрэгжүүлээгүй.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлээ.

5.3 Зөвлөмж

1. Улсын тэмдэгтийн хураамжтай холбоотой асуудал

Илрүүлэлт: /Нөхцөл байдал, үр дагавар, нийцээгүй хууль тогтоомж, стандартын заалтыг бичих/

Улсын тэмдэгийн хураамжийг 4,500.0 мянган төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 3,063.8 мянган төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөнөөс 1,436.2 мянган төгрөг буюу 32.02 хувиар тасарсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх *"Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ"* 41.2.1 дэх *"хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх"* заалтыг мөрлөж ажиллаагүй.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх *"Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ"* 41.2.1 дэх *"хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх"* заалтыг мөрлөж ажиллах.

2. Малын тоо толгой холбоотой асуудал

Тэшиг сумын ОНХС	2	1136.8	1	136.8			1	1000.0				
Тэшиг сумын Соёлын төв	1	375.0	1	375.0								
Тэшиг сумын ХХС	1	4053.9					1	4053.9				
Дүн	17	17050.8	10	6557.0	1	0	6	10493.8				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Тэшиг сумын ТТЗ	1	0	1	0		
Тэшиг-Ус ОНӨААТҮГ	1	0			1	0
Тэшиг сумын ОНХС	1	742595.5			1	742595.5
Дүн	3	742595.5	1	0	1	742595.5
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Дүн						
Нийт дүн						